

Соёлын бодлогын загвар, туршлага болон Монгол Улсын соёлын бодлогын зарим асуудал

Model and experience of cultural policy and some issues of Mongolian cultural policy

Аюурзанын Цанжид¹

Доктор (Sc.D), профессор
Шинжлэх Ухааны Академийн
Философийн хүрээлэн
Бодлого судлал, улс төрийн эдийн
засгийн салбар
tsanjid@mas.ac.mn

Tsanjid Ayurzana

Doctor (Sc.D), professor
Department of Policy Studies & Political
Economy, Institute of Philosophy,
Mongolian Academy of Sciences
tsanjid@mas.ac.mn

Хураангуй:

Эл өгүүлэлд Монгол Улсын соёлын бодлогын зарим асуудлыг Европын орнуудын соёлын бодлогын туршага, соёлын бодлогын загвар, соёлын бодлогын талаарх эрдэмтэн судлаачдын бүтээл, олон улсын байгууллагуудын соёлын бодлогын талаарх баримт бичиг дэх соёлын бодлогын зорилго зэрэгтэй харьцуулахын зэрэгцээ соёлын орчны өөрчлөлттэй холбон Монгол Улсын соёлын бодлогын загвар, зорилго, хэрэгжилтийн зарим асуудлыг авч үзсэн болно.

Түлхүүр үгс: соёлын бодлого, соёлын бодлогын загвар, соёлын дархлаа, үнэт зүйлс

Abstract:

The article compares some issues of Mongolia's cultural policy with the experience of cultural policy in European countries, the model of cultural policy, the works of scholars on cultural policy, and the goals of cultural policy in the documents of cultural policy of international organizations. aims and some implementation issues are discussed.

Keywords: cultural policy, cultural policy models, cultural immunity and values

I. Оршил

Орчин үед даяаршлийн давалгаанд хамгийн их өртөж буй салбар бол соёлын салбар юм. Хэдийгээр дэлхийн байдал халдварт тахал, дайн дажны улмаас хэдэн жилийн өмнөх байдлаасаа өөр болж байгаа ч гэсэн аж үйлдвэрийн ээлжит хувьсгал, мэдээлэл, холбооны технологийн ололтын үр дүнд даяаршил хумигдах төлөв бага байна. Даяаршил нь улс үндэстнүүдийн

¹ © Зохиогч. 2022. Сэтгүүлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээл нь зохиогчийн оюуны өмч байх бөгөөд (CC BY- <https://creativecommons.org/licenses/by/4.0/>) нөхцөлийн хүрээнд ашиглана уу.

соёлын харилцааг эрчимжүүлж, ололтыг нь дэлгэрүүлэх, соёлыг нь харилцан таниулах талаар эерэг нөлөөтэй байгаа боловч, нөгөө талаар хэл соёл уугуул дүр төрхөө алдах, устах, уламжлал мартагдах, бүдгэрэх аюул бас байгааг тэмдэглэх нь зүйтэй юм.

Соёлыг үндэстэн хоорондын харилцан ойлголцол, нөхөрлөлийн, эдийн засаг, нийгмийн хөгжлийн хүчин зүйл хэмээн үзэх боллоо. Энэ бүхнийг харгалзан үндэсний соёлын бодлогыг боловсруулах, судлахад улс орон бүр анхаарал тавьдаг боллоо. Судалгаа шинжилгээний ажил ч эрчимжиж байна.

Судлаачид соёлын бодлого гэж юу болохыг тодорхойлохыг оролдож, олон янзын тодорхойлолт буй болжээ. Анх 1967 онд Монакод болсон ЮНЕСКО-гийн дугуй ширээний ярилцлагын үед “соёлын бодлого” хэмээх нэр томъёог эргэлтэнд оруулсан нь уг сэдвийг судлахад түлхэц болсон байна. Тэр ярилцлагын үеэр тавигдсан “Соёлын салбарын бодлогын тухай урьдчилсан судалгаа” хэмээх илтгэлд соёлын бодлого гэдэг бол “соёлын салбар дахь төрийн үйл ажиллагаан үндсийг бүрдүүлдэг үйл ажиллагааны зарчим, захиргааны болон санхүүгийн үйл ажиллагааны журам зэргийг багтаасан цогц” хэмээн тодорхойлжээ[1]. Эл тодорхойлолтод зөвхөн соёлын салбарт явуулах үйл ажиллагааны зарчим, хэрэгслийн талыг голлон анхаарсан байна. Хэдий тийм боловч ерөөс соёлын бодлогын тухай асуудлыг хөндөж, дэлхий нийтийн анхаарлыг хандуулснаараа уг дугуй ширээний ярилцлага ихээхэн ач холбогдолтой болжээ.

Аливаа салбарт явуулах төрийн бодлого нь тодорхой зорилгод чиглэсэн байдгаараа онцлог. Үүнийг бодлого судлаачид анхаарч зарчим, хэрэгсэл төдийгүй зорилгыг багтаан соёлын бодлогыг тодорхойлох болжээ. Үүний анхдагчдын нэг нь Францын соёлын бодлого судлаач Августин Жерар юм. Тэрбээр Женевьев Гентилтэй хамтран бичсэн өгүүлэлдээ соёлын бодлого гэдэг бол *«бүлгүүдийн тодорхойлсон, эрх бүхий байгууллагуудын хэрэгжүүлдэг өөр хоорондоо нягт холбоо бүхий зорилго, практик зорилт болон хэрэгслүүдийг багтаасан систем юм»*[2]. Эл тодорхойлолтод соёлын бодлогын агуулгын талыг төдийлэн тодорхой дурдаагүй “зорилго, зорилт” гэдгээр хязгаарласан нь улс үндэстэн бүрийн соёлын бодлогын агуулыг тодорхойлдог зорилго, зорилт өвөрмөц байдгийг харгалзсан хэрэг биз ээ. Харин А.Е.Хренов бичсэн өгүүлэлдээ соёлын бодлого гэж *«...соёлын янз бүрийн үнэт систем, хэлбэрийг ... хадгалах, өөрчлөх, зохион байгуулахад чиглэсэн»* үйл ажиллагаа хэмээн ойлгоно хэмээжээ[3]. Энэ бол соёлын бодлого нь соёлын “үнэт зүйлсийг” хөндөж байдаг гэсэн санааг цухалзуулж байна.

Соёлын бодлого нь шинжлэх ухааны үндэстэй байх ёстой. Тийм учраас тодорхой онол, арга зүйд тулгуурласан байна. Бодлогын энэ төвшинд соёлын бодлогын философи, үзэл суртал, үнэт зүйлс, бодлого явуулагчдын зорьж тэмүүлж буй чин зорилго (идеал) тодорхойлогдоно. Өрөөр хэлбэл, энэ төвшинд ард иргэдийн оюун санааны төрх төлөв ямар байхыг тодорхойлно гэсэн үг юм. Энэ бол соёлын салбар дахь үйл ажиллагааг ямар нэг үзэл суртал юмуу, уламжлалт ч бай, шинэ ч бай ямар нэг агуулга,

хэлбэрээр хязгаарлана гэсэн үг биш нь ойлгомжтой. Гэвч ийм хүрээ, хязгаар улс бүрд өөр өөр байдаг.

Соёлын бодлого бол байнга хувьсаж, нийгмийн тухайн үеийн хэрэгцээгээр өөрчлөгдөж байдгийг дэлхий дахины туршлага харуулж байгаа юм. Үүнийг соёлын мөн чанар, түүний нийгэмд гүйцэтгэх үүргийн талаарх парадигмын өөрчлөлт хэмээн үзэж болно. Парадигмын эл хувьслыг Европын орнуудын жишээгээр хөөж үзэх нь манай орны хувьд туршлага болно. Дэлхийн хоёр дугаар дайны дараагаар соёлыг зөвхөн элитийн хүрээгээр үл хязгаарлан өргөн олон түмний хүртээл болгохыг чухалчилж байжээ. Соёлыг хөгжүүлэхээс гадна дайны хүнд хэцүү жилүүдэд олон нийтэд учирсан дарамтыг арилгаж, сэтгэл санааг сэргээх, идэвхжүүлэх, дайнч сэтгэлгээг арилгах зорилго үүнд давхар агуулагдаж байлаа. Соёлыг өргөн олон түмний хүртээл болгохын тулд соёлын боловсролыг дээшлүүлэх янз бүрийн хөтөлбөр хэрэгжүүлэх, музейг үнэгүй үзүүлэх, радио, телевизийн нэвтрүүлгүүдийн соёлтой холбоотой агуулгыг олшруулах зэрэг ажлуудыг хийж байжээ. Соёлын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд төр хүчтэй оролцож, төвлөрсөн зохицуулалтыг хийж байжээ.

Гэвч 70-аад оны үеэс эл бодлогыг төр хэтэрхий оролцож, нийгмийн цөөнх хэсэг болох элитийн соёлыг олон нийтэд тулган хүлээлгэж байгаа нь ардчиллын зарчимд нийцэхгүй байна хэмээн шүүмжлэх болжээ. Үүнээс үүдэн улс орнуудын соёлын бодлогод өөрчлөлт орж, соёлыг ардчилах хөдөлгөөн эхэлжээ. “Соёлыг бүх нийтэд хүртээх” гэсэн уриа “соёлыг хүн бүрт” гэсэн уриагаар солигдсон байна. Энэ үеийн соёлын бодлогын онцлог нь нэгд, түүхэн, болон нийгэм, соёлын хүчин зүйлсийг харгалзан хүнийг хөгжүүлэх, орон нутгийн иргэдийн соёлын үйл ажиллагаанд оролцохыг идэвхижүүлэн адилсалыг хүчтэй болгох, хоёрт, хүмүүс соёлын бүтээгдэхүүнийг хэрэглэх төдийгүй өөрснөө бүтээх, гуравт, соёлын үйл ажиллагаанд төвийн оролцоог багасгах, орон нутгийн байгууллагуудыг үүргийг нэмэгдүүлэх зэрэг байжээ. Улмаар 80-аад оны соёлын бодлого нь соёлыг ардчилах үзэл санаанд суурилах болжээ. Европын орнууд хооронд ялгаатай байсан боловч соёлыг бүтээх, шийдвэр гаргахад орон нутаг, соёлын байгууллагууд, уран бүтээлчид өргөнөөр оролцох болсон байна.

XX зууны 80-аад оны эцэс, 90-ээд оны эхээр соёлын бодлогод өөрчлөлт орж соёл бол нийгмийг хөгжүүлэх хэрэгсэл мөн гэсэн үзэл баримтлал буй болжээ. Соёлын бүхий арга хэмжээ нь нийгэм, эдийн засгийн үр нөлөөтэй байдаг гэж үзэх болсон байна. Тийм учраас жишээ нь, соёлын арга хэмжээг ашиглан эрүүл аж төрөх ёсыг сурталчлах болсон аж. Түүнчлэн бизнесийн хүрээнийхэн өөрсдийн зорилгоор соёлыг ашиглаж, түүнд хөрөнгө оруулах болжээ. Соёлтой шууд холбоогүй төрийн байгууллагууд соёлын үйл ажиллагаанд татагдан оролцох болжээ. Улмаар эдийн засгийн бодлогод ч өөрчлөлт орж уламжлал ёсоор уг бодлогын гол зорилт бол иргэдийн амьдралын төвшинг дээшлүүлэхэд л анхаардаг байсан бол соёлын салбарын хөгжилд ихээхэн анхаарал тавих болсон байна. Гэвч үүний зэрэгцээ соёлыг

зөвхөн улс төр, нийгэм, эдийн засгийн зорилгыг хэрэгжүүлэх хэрэгсэл болгон хувиргах бий гэсэн болгоомжлол гарах болсон байна.

Соёлын бодлогын онол арга зүй нь уг бодлогын загварт тусгалаа олж, практик үйл ажиллагааг хэрэгждэг. Судлаачид соёлын бодлогыг янз бүрийн байдлаар ангилж, олон загварыг санал болгосон байдаг. Хамгийн ерөнхий байдлаар соёлын бодлогыг төрийн бюрократ болон зах зээлийн загвар хэмээн ангилж болно. Төрийн бюрократ загвар нь соёлын бодлогыг тодорхойлох хэрэгжүүлэхэд төр гол үүргийг гүйцэтгэхэд оршино. Тийм учраас зарим судлаач (Абрахам Моль, Лев Востряков)[4] түүнийг гэгээрүүлэлтийн загвар ч гэж нэрлэсэн байдаг. Мөн этатист (А.Е.Хренов) гэж нэрлэсэн байна. Тэдгээрийн уг загварыг тодорхойлсон байдал нь зарим ялгаатай ч гэсэн ерөнхийдөө соёлын бодлогод төр гол үүргийг гүйцэтгэдэг гэж үздэгээрээ төстэй учраас нэг загварын тухай ярьж байна хэмээн үзэж болно. Төр хууль тогтоох, улс төр, үзэл суртлын хяналт тогтоох, санхүүжүүлэх зэрэг аргаар замаар соёлын хүрээг удирдаж байдаг аж. Үүнд ялангуяа төв байгууллагуудын эрх мэдэл их байдаг байна. Төрийн төв байгууллагууд үйл ажиллагааг төлөвлөж, улс орны соёлын амьдралыг залж, чиглүүлэж байдаг.

Соёлын бодлогын ийм туйлширсан хэлбэр социалист улсуудад хэрэгжиж байсан. Сербийн судлаач М.Драгичевич-Шешич Франц, Швед зэрэг орны соёлын бодлогыг мөн ийм загварт хамааруулсан байна (Востряков). Соёлын бодлогод төв байгууллагууд голлох байр суурь эзэлдэг загвар зөвхөн өнгөрсөн үед байсан бөгөөд орчин үед орон нутаг илүү их үүрэгтэй байх ёстой гэж бас үзэж болохгүй бололтой. Норвегийн Соёлын Зөвлөлийн гишүүн Пер Мангсет соёлын бодлого төвийн ивээлд байх нь зөв гэдэг талаар хэд хэдэн үндэслэл гаргасан байна. Нэгд, төрийн зохицуулалт нь иргэн хот хөдөө хаана ч амьдарч байсан түүнд соёлын үнэт зүйлсийг хүртэх шударга бөгөөд тэгш боломжийг олгох аж. Хоёрт, уран сайхны болон соёлын бусад бүтээлч үйл ажиллагаа нь өвөрмөц онцлогтой байдаг учраас түүнийг орон нутгийн эрх мэдэлтнүүд болон зах зээлээс хамгаалах хэрэгтэй байдаг байна. Учир нь зарим тохиолдолд шинэ бүтээл нь нийгэмд хэвшиж тогтсон хэм хэмжээнээс гажих, дундаж иргэн ойлгохгүй байх тохиолдол гардаг байна. Гуравт, соёлын бодлогод эрх мэдлийг орон нутаг руу их тараах нь нутгархах байдлыг үүсгэх, тухайн орон нутгийн үнэлэмжийг адилсалын суурь болгодог учраас орчин үеийн олон янз байдалтай нийгэмд тохирохгүй аж.

Төрийн бюрократ загварыг эрх баригчдын юмуу нийгмийн элит хэсгийн соёлыг бусдад тулган хүлээлэгдэг, соёлын бусад шинэлэг төрөл зүйл, хэлбэрт хөгжих бололцоо олгодоггүй гэх юмуу бүр хааж боож байдаг хэмээн шүүмжилдэг. Ийм шинжтэй дэд загвар бол соёлын национализм буюу төрийн зүгээс үндэсний олонхийн соёлыг дэмжиж, цөөнхөд соёлын хувьд уусахад хүргэдэг загвар юм. Ихэнхи тохиолдолд төрийн бюрократ загвар нь давамгайлалт соёлыг илүүтэй дэмждэг байна.

Зах зээлийн загварын үндсэн зарчим бол төр соёлын хүрээг зохицуулахаас өөрийгөө чөлөөлж, зохицуулалтыг зах зээлийн “үл үзэгдэх гар”-т даатгах явдал юм. Соёлын үйл ажиллагааны үр ашиг, бүтээлийн үнэ цэнэ нь түүнээс орох ашиг болдог байна. Соёлын арга хэмжээний бизнесийн ашиг, олон түмнийг татах чадвар зэргийг гол үзүүлэлт болгодог байна. Тийм ч учраас зах зээлийн загвар голлож байгаа үед олон түмний буюу орчин үед “массын соёл” гэж нэрлэдэг соёлын зүйлс давамгайлах хандлагатай болдог байна. Зах зээлийн загварыг бас либераль загвар хэмээн нэрлэж болох юм.

Соёлын бодлогыг ийнхүү ерөнхий байдлаар хоёр ангилж болохоос гадна судлаачид өөр олон загварыг санал болгосон байдаг. Дээр дурдсан Драгичевич-Шишин либераль, төрийн бюрократ, үндэсний чөлөөлөх, шилжилтийн үеийн гэсэн дөрвөн загварыг санал болгосон байна. Энэ нь хөгжингүй орнуудын соёлын бодлогын загвараас гадна хөгжиж байгаа орнууд, социалист байсан орнуудын соёлын бодлогыг тусгайлсан загвар болгосон хэрэг юм. Шилжилтийн үеийн загварын онцлог нь хэдийгээр эдгээр улсууд ардчилсан дэглэмтэй болсон боловч соёлын бодлогыг өмнөх үеийн захиргаадаа аргаар явуулж байгаа явдал аж. Ийм бодлого нь үндэсний соёлыг хэт дөвийлгөх гадаадын соёлт ертөнцийн соёлыг хаах хандлагатай болож байна гэж үзжээ.

Германы Соёлын судалгааны хүрээлэнгийн захирал Андреас Визанд соёлыг нийгмийн зүгээс дэмждэг байсан уламжлал дээр суурилсан загвар, зах зээлийн загвар гэсэн хоёр загварыг санал болгосон байна. Визандын тодорхойлсон эл хоёр загвар манай улсын соёлын бодлогын зарчмуудыг боловсруулахад сургамжтай байж болох учраас түүнийг арай дэлгэрэнгүй авч үзье. Эхний загварын агуулгыг үзвэл энэ нь төрийн бюрократ загвартай төстэй юм. Түүний гол зүйл нь:

- Засгийн анхаарал музей, театр, номын гэх мэтийн санхүүжилт авдаг соёлын байгууллагуудад төвлөрч, уран бүтээлчид “үнэн”-ийг дэлгэрүүлэгч маягтай байх ба туршилтын гэмээр соёлд бага ач холбогдол өгөх,
- Хүлээн зөвшөөрөгдсөн урсгалуудын хүчээр соёл, урлаг дахь бүтцийн тэнцвэрийг хадгалах,
- Нэгэнт гол санхүүжилт төрөөс гардаг учраас төлөвлөх, хөтөлбөр гаргах зэрэг төрийн зохицуулалт чухал,
- Төлөвлөлтийг улсын төвшинд хийх ба соёлын гадаад харилцаа гол төлөв дипломат шугамаар явах,
- Удирдлагын зорилгоор төрөөс янз бүрийн уран сайхны зөвлөлийг буй болгох зэрэг аж.

Гэвч эл загвар зарим сул талтай аж. Үүнд:

- Инноваци гарах нөхцөл маш бага. Шинэ бүтээл, ялангуяа залуу уран бүтээлчдийн бүтээлийг гол төлөв үгүйсгэдэг.
- Бодлого гаргагчид болон хэрэгжүүлэгчид соёлын хөгжил, түүн дэх инновацийн талаар мэдлэг багатай байдаг учраас соёл, урлагийн уламжлалт хэлбэрүүдийг илүүд үзэх хандлагатай байдаг.

- Төлөвлөлтийг уян хатан болгох хэрэгслүүдийг боловсруулахдаа хангалтгүй
- Шийдвэр гаргалтад захиргаа давамгайлдаг учраас уран бүтээлчдийн нөлөө хязгаарлагдмал байдаг.

Соёлын бодлогын зах зээлийн маягтай загварын гол зүйлс бол:

- Соёлын амьдрал зах зээлээр зохицуулагдах,
- Бодлого гол нь эдийн засгийн хөгжилд чиглэх,
- Өндөр болон олон түмний соёл хоорондын уламжлалт хаалт багасах,
- Соёлын бодлогын үндсэн ойлголт нь “соёлын холимог эдийн засаг” болон арилжааны ивээн тэтгэлтийн үзэл санаанд тулгуурласан “соёлын менежмент” байх,
- Орон нутгийн төвшин дэх соёлын хөгжилд гол анхаарлаа тавих. Гэвч жишээ нь, Европод орон нутагт олон үндэстний соёл хүчтэй болсон.
- Соёлын бодлогыг боловсруулахад соёлын элит, ялангуяа урлагийнхан чухал үүрэг гүйцэтгэх. Үүнд нь шинжээчид, ялангуяа бизнесийн салбарын зах зээлийн мэргэжилтнүүд туслах зэрэг аж.

Визанд зах зээлийн загварын зөрчилтэй талуудыг бас тодорхойлсон байна. Үүнд:

- Байнга санхүүжилт хэрэгтэй байдаг боловч эдийн засгийн хувьд ашиггүй соёл, урлагийн үйл ажиллагаа ирээдүйгүйд тооцогдох,
- Үр ашиг гол шалгуур нь болдог. Уран бүтээлчийн хүсэж байгаа, үнэ цэн нь ашгаар тодорхойлогддоггүй бүтээлийг санхүүжүүлэх ивээн тэтгэгчийг олоход бэрхшээлтэй,
- Олон улсын шинжтэй ажиллагаанд цөөхөн орон оролцдог (жишээ нь, Европын Холбоо). Ихэвчлэн үүнд үндэстэн дамнасан, тэгэхдээ Америкийн корпорацууд хяналтдаа байлгадаг зугаа цэнгэлийн үйлдвэрлэл голлодог,
- Үзэгч, сонсогчдын сонирхлыг хэтрүүлж үнэлснээс үүдэн зах зээлийн тэнцвэр эдийн засгийн үр ашиг болон бүтээлийн агуулгын хувьд алдагддаг.
- Шинжээч байгууллагууд ёс төдий үүрэг гүйцэтгэх ба соёл, урлагийн менежерүүдийн эрх мэдэл хэт их болох

Эцэст нь, Европын шинжээчдийн хэсгээс санал болгосон загваруудыг эрхбиш дурдах нь зүйтэй. Тэд соёлын бодлогыг ангилахдаа асуудлын улс төрийн талыг бус санхүүжилтийн онцлогийг харгалзан соёлын бодлогын дөрвөн загвар байна хэмээн үзжээ. Үүнд, америк загвар, төвлөрөлгүй загвар, “сунгасан гар”-ын загвар (the arms-length principle), төвлөн удирдах загвар зэрэг болно. Эдгээрийн агуулгыг товч авч үзье.

1. Америк загвар. Төрийн оролцоо бага. Үндэсний урлагийн сан хэмээх төрийн агентлаг байдаг боловч түүний эрх хэмжээ, түүнд олгодог санхүүжилт хязгаарлагдмал байдаг байна. Хувийн санхүүжүүлэгчид, ивээн тэтгэгчид, хувь хүмүүс санхүүжилтийн ихэнхийг гаргадаг байна.

2. Төвлөрсөн бус загвар. Муж, орон нутгийн байгууллагууд соёлын санхүүжилтийг хариуцана. Соёлын яам байхгүй учраас төв засгийн газар соёлын салбарт нэмэлт санхүүжилт олгох төдий хязгаарлагдмал үүрэгтэй. Санхүүжилт нь төр, хувь, олон нийтийн гэсэн холимог бүтэцтэй. Соёлын бодлогыг хуулиар тодорхойлдог. Соёлын бодлогын ийм загвар бүхий улсын жишээ бол ХБНГУ аж.
3. Соёлын бодлогын ийм загварт засгийн газар соёлын санхүүжилтийг ерөнхий дүнгээр нь тодорхойлох боловч, түүний хуваарилалтад үл оролцоно. Эл үүргийг захиргааны хараат бус байгууллагууд эрхлэх боловч тэд эл эрхийг цааш нь дамжуулан шинжээчдийн тусгайлсан хороод, бүлгүүдэд өгдөг байна. Ийм бодлого нь нэгд, улс төрчдийг соёлын санхүүжилтээс “сунгасан гар”-ын зайтай байлгах, хоёрт, уран бүтээлчид, соёлын байгууллагуудыг улс төрчдийн шууд оролцоо болон хууль бус цензурээс хамгаалах гэсэн хоёр зорилгыг агуулдаг байна. Их Британи, Канад, Скандинавын орнуудын соёлын бодлогыг эл загварт хамруулж болох ажээ.
4. Дөрөв дэх буюу төвлөн удирдах загварт захиргааны дээд төвшинд бодлогыг тодорхойлж, шууд санхүүжүүлэхийн зэрэгцээ соёлын салбарын үйл ажиллагааг нийтэд нь зохицуулж, байгууллага, хүмүүсийн үйл ажиллагааг уялдуулдаг аж. Тэгэхдээ бодлогыг тодорхойлох, санхүүжилтийг хуваарилахдаа шинжээчид, хараат бус мэргэжилтнүүд оролцдог янз бүрийн комиссийн саналыг харгалзан шийдвэрлэдэг байна. Тиймээс төвийн ийм байгууллага нь уран бүтээлчдийн санал, соёлын байгууллагуудын хөтөлөр, төлөвлөгөөнд анхааралтай хандаж, идэвхижүүлэгч, уялдуулагчийн үүргийг гүйцэтгэдэг байна.

Соёлын бодлогын загварыг боловсруулахад манай улсын гео-улс төрийн байршил, хүн амын тоо, бүтэц, хөгжлийн хэрэгцээ зэрэг олон зүйлийг харгалзахын зэрэгцээ олон улсад буй соёлын бодлогын загвар, туршлагыг судалж, туршлага, сургамжаас нь суралцах нь зүй юм. Соёлын тухай хуулийн агуулгаас үзвэл Монгол Улсын соёлын бодлогыг загварын хувьд төвлөн удирдах загварт хамааруулж болно. Соёлын удирдлага нь дээрээс доош шаталсан байгууллагуудаас үндсэндээ бүрдэж байгаа бөгөөд санхүүжилтийн хувьд ч төрийн санхүүжилт давамгайлдаг, хөрөнгийн хувиарлалт ч төвийн эрх мэдэлд байна. Соёлын үйл ажиллагаанд олон нийт оролцох талаар заасан боловч, түүнийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл тодорхой бус юм. Ялангуяа соёлын салбарын мэргэжлийн холбоодын оролцооны талаар цухас дурдсан нь удирдлагын төвлөрлийг улам ихэсгэж байна.

Тус хуулийн 22.1.7-д “соёл, урлагийн мэргэжлийн холбоод, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрт дэмжлэг, туслалцаа үзүүлэх” үүргийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад үүрэг болгосон, мөн 26.4 -д “соёлын салбарын зарим ажил, үйлчилгээг мэргэжлийн төрийн бус болон хувийн

хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлж болох бөгөөд уг байгууллагад тавих нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлт болон холбогдох журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэжээ[5]. Энэ бүхнээс үзвэл манай улсын соёлын бодлого нь дээр Драгичевич-Шишиний ангилал дахь шилжилтийн үеийн загварт хамаарч байгаа гэж болно. Уг хуулиар соёлын асуудал эрхэлдэг төрийн захиргааны байгууллага “түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан соёлын үйл ажиллагаа эрхлэхийг хориглох арга хэмжээг авах” үүрэг хүлээж байгаа нь эл дүгнэлтийг батгагах нэг баримт юм. Эл заалтыг хэрэхн яаж хэрэгжүүлэх вэ гэдэг нь ойлгомжгүй байгаагаас гадна хориглох ангилалд багтах бүтээлийг хэрхэн тодорхойлох вэ гэдэг нь бараг боломжгүй зүйл юм. Зарим хүний ойлголтоо өнөө үед манай орны кино театруудад гарч байгаа, телевизээр үзүүлж байгаа киноны ихэнхийг нь эл хориглох заалтад хамааруулж болно. Гэтэл зарим хүний үзлээр эдгээрийг эл ангилалд оруулж болохгүй. Өөрөөр хэлбэл шалгуурын асуудал төвөгтэй гэсэн үг юм. Тийм болохоор эл заалтаас цензур ямар нэг хэмжээгээр “үнэртэж” байна хэмээн үзэж болно. Хэрвээ соёлын үйл ажиллагааг хориглох шаардлагатай бол түүнийг зөвхөн шүүхээр л шийдвэрлэх нь зүйтэй байж болох юм.

Орон нутгийн нөөц хомс, соёлын ажилтнууд, байгууллага өмнөх үеэс уламжлан төвлөрсөн байршилтай, олон ястантай, гаднын нөлөө хүчтэй байгаа өнөөгийн нөхцөлд соёлын бодлогыг төвлөрсөн байдлаар тодорхойлж хэрэгжүүлэх нь зүйтэй. Гэвч ардчиллын нөхцөлд төрийн төв байгууллагын эрх мэдлээр хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй зарим асуудлыг анхаарвал соёлын бүтээлийн чанар чансаа, агуулга, ёс зүй зэрэг олон асуудлаар мэрэгжлийн холбоод, шинжээчид, мэрэгжилтнүүдийн байнгын өргөн оролцоонд түшиглэх, орон нутгийн оролцооны хувьд ч эрх, үүргийг ялгавартай тогтоох аргыг ямар нэг хэмжээгээр турших хэрэгтэй юм. Ийм зорилгын үүднээс мэрэгжлийн холбоодын эрхийг өргөтгөх, тэдгээрийг бэхжүүлэх, нэр хүндийг нь дээшлүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь тустай болохыг олон улсын туршлага харуулж байна. Түүнчлэн шүүмж судлалын мэрэгжилтнүүд, байгууллагыг энэ ажилд өргөнөөр татан оролцуулах нь чухал байдаг байна. Ийм тохиолдолд л соёлын бодлогын төвлөрсөн загвар үр дүнгээ өгч болох юм.

Соёлын тухай хуульд соёлын хүрээг “Соёлын үйл ажиллагааны чиглэл” гэсэн 9-р зүйлээр тодорхойлж байна. Соёлын салбарыг төрийн захиргааны төв байгууллагын хуулинд заасан чиг үүргээс өргөн тодорхойлсон нь зүйтэй юм. Харин хэлний тухай, үндэсний уламжлалт зан заншил зэрэг асуудлыг орхисон юмуу эсвэл ямар үйл ажиллагааны хүрээнд хамрагдана хэмээн үзсэн байж болох юм. Энэ нь хуулийн зорилгод байгаа эдгээр асуудлын талаарх заалттай зөрчилдөж байна хэмээн үзэж болох юм. Хэл бол үндэсний сэтгэлгээг нэгдмэл байдлаар төлөвшүүлэх, үндэсний адилсалын маш чухал хэрэгсэл юм. Ямар ч уран бүтээл уран бүтээлчийн сэтгэл оюунд хэлний тусламжтайгаар анх бууж, мөн хэлний тусламжтайгаар илэрхийлэгдэнэ. Энэ нь үгээр илэрхийлэгддэг төдийгүй, дүрслэх урлаг

мэтийн бусад төрөлд ч хамааралтай юм. Зан заншил бол үндэстний өөртөө орших өвөрмөц байдлын илэрхийлэл байдаг. Түүнд хүний нийгэмд эзэлх байр суурийн тухай ойлголт, хүн хоорондын харилцаа, хүний сав шимийн ертөнцөд хандах байдал, эх оронч үзэл, иргэний хариуцлага гэх мэт маш олон зүйл багтаж байдаг учраас хүүхэд залуусыг монгол хүн болгож төлөвшүүлэх анхдагч хэрэгсэл юм.

Соёлын салбарын хүрээ ийм өргөн байгаагаас үүдэн энд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, хүмүүсийн хамтын үйл ажиллагаа чухал болно. Тийм учраас бодлогод тэдгээрийн хамтын ажиллагааны арга хэрэгслийг тодорхойлох нь түүний хэрэгжилтэд нөлөөтэй юм. Хүүхэд бага наснаасаа эхлэн соёлын өв, уран зохиол, хөгжим, дүрслэх урлагийн бүтээлтэй танилцан, тэдгээрт дур сонирхолтой болж, үндэсний дэвшилтэт зан заншил, хэм хэмжээг дадал хэвшил болгож чадвал иргэний соёлын боловсролын ихэнхи хувийг олголоо гэсэн үг юм. Хүүхэд залуучууд соёлын боловсролоо цаашдаа бие даан дээшлүүлдэг, соёлын үнэт зүйлст хувийн үнэлэлт дүгнэлт өгөх чадвартай бол бие хүний хувьд хувийн өвөрмөц соёлын таашаал төлөвшилтэй болно. Тийм учраас соёлын боловсролын үйл ажиллагаа сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагуудад төвлөрч байх хэрэгтэй юм. Тэгэхдээ юм болгоныг заавал хичээл болгон оруулах эрмэлзэл нь тухайн тэр асуудлаар хүүхдэд боловсрол олгоход ч, хүүхдэд шинжлэх ухааны боловсрол олгоход ч тустай биш юм.

Орчин үеийн нөхцөлд сургалтын хөтөлбөрт уламжлалт болон шинжлэх ухаан, технологийн хөгжлийн дагуу оруулах шаардлагатай болж байгаа шинэ хичээлүүдийг багтаахад бэрхшээлтэй болж байна. Тиймээс боловсролын болон соёлын байгууллагуудын хамтын ажиллагааны арга хэлбэрийг улам тодорхой болгох хэрэгтэй юм. Хичээлээс гадуур зохиогддог олон төрлийн ажил, зуны болон өвлийн амралтаар зохиогддог арга хэмжээнүүдэд соёлын байгууллагууд, урлаг соёлын ажилтнуудын оролцоог өргөтгөх, тэднийг урамшуулах, санхүүжилтийн асуудлыг аль нэг байгууллагын нь төсөвлөх, үүнд төр, хувийн хэвшлийн байгууллагууд, гэр бүлийн үүргийг нэмэгдүүлэх шаардлагатай юм. Бусад улс оронд олон жилийн практикаар хэвшиж тогтсон ийм төрлийн үйл ажиллагаа манайд төдийлэн өргөн хүрээтэй бус байгаа нь манай орны онцлог учраас үүнийг бодлогод заавал харгалзах нь зүй юм.

Соёлын бодлогод чухал байр суурь эзэлдэг асуудал бол түүний зорилго юм. Манай улсын соёлын бодлогын зорилгыг “Соёлын тухай хууль”-ийн 4-р зүйлд тодорхойлсон байна.

- соёлын өвийг төрийн онцгой анхаарал, ивээлд байлгах;
- эх хэл, бичиг үсэг, үндэсний түүх, соёл, өв уламжлал, зан заншил зэрэг үндэсний үнэт зүйлийг эрхэмлэн хөгжүүлэх, нандигнан өвлүүлэх замаар үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх;
- соёлын илэрхийллийн олон төрөлд хүндэтгэлтэй хандах, хамгаалах, дэмжих;

- соёлын үнэт зүйлийг судлах, өвлөх, уламжлуулах нөхцөл бүрдүүлэх замаар соёлын дархлаа бүхий монгол хүнийг төлөвшүүлэх;
- соёлын үнэт зүйлийг бүтээн туурвих таатай орчныг бий болгох, эдийн засаг, нийгмийн хөгжилд соёлын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, соёлын байгууллагын бие даасан, санхүүгийн тогтвортой байдлыг хангах;
- хувь хүний бүтээлч хөгжил, авьяас, ур чадварыг хөгжүүлэхэд соёлын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, соёлын боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих, иргэнийг соён гэгээрүүлэх;
- соёлын үйл ажиллагаа, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийг хөрөнгө оруулалт, зээл, татварын бодлого болон бусад хэлбэрээр дэмжих;

Түүнчлэн Төрөөс соёлын талаар баримтлах бодлого хэмээх баримт бичигт бодлогын зорилгыг тодорхойлжээ. Төрөөс соёлын талаар баримтлах бодлогын зорилго нь “соёлын үнэт зүйлийг иргэд бүтээн бий болгох, хүртэх, эзэмших, уламжлах болон соёлын өвийг найдвартай хадгалах, хамгаалах орчин нөхцөлийг бүрдүүлэх, уламжлалт соёлоо дэлхий нийтэд сурталчлан таниулах, үндэсний хөгжилд соёлын эзлэх байр суурь, оруулах хувь нэмэр, үр ашгийг дээшлүүлэх, соёлын үйл ажиллагаанд иргэн, гэр бүл, байгууллагын оролцоог нэмэгдүүлж, монгол хүнийг бага наснаас нь хүмүүнлэг, оюунлаг, соёл, уламжлалаа дээдэлдэг иргэн болгон төлөвшүүлэх” зэрэг ажээ. Эдгээр баримт бичгээр тодорхойлсон соёлын бодлогын зориг ерөнхийдээ ижил байгаа боловч зарим зөрөө байгаа нь ажиглагдана.

Хуулиар тодорхойлсон зорилго дотор “соёлын өвийг төрийн онцгой анхаарал, ивээлд байлгах” нь ерөнхий бөгөөд соёлын өвийг анхаарах, ивээх гэдэг нь чухам яана гэсэн утгатай болох нь тодорхойгүй байхад бодлогын баримт бичигт “соёлын өвийг найдвартай хадгалах, хамгаалах орчин нөхцөлийг бүрдүүлэх” гэсэн илүү тодорхой бөгөөд төрд хамгаалах үүргийг шууд ногдуулж байгаагаараа чухал юм. Хуулиар тодорхойлсон зорилго дотор “соёлын илэрхийллийн олон төрөлд хүндэтгэлтэй хандах, хамгаалах, дэмжих” гэсэн заалт байгаа нь соёлын ардчилал, шинэ залуу уран бүтээлчид, шинэ санаа санаачилгыг дэмжих агуулгатай байна.

Соёлын бодлогод гол байр суурийг эзэлдэг асуудал бол соёлын өвийг хамгаалах, соёлын шинэ бүтээгдэхүүнийг буй болгох, иргэдийн оюун санааны нийтлэг дүр төрхийг төлөвшүүлэх зэрэг юм. Юуны өмнө үндэсний соёлын өвийг хамгаалах, үндэсний хэлний ноёрхолыг тогтоох гэх мэтээр соёлын салбарт “үндэсний” хэмээх тодотголтой үнэт зүйлсийн баталгааг хангахад чиглэсэн бодлогыг “соёлын национализм” хэмээн нэрлэх нь бий. Хүн ам цөөн, хөгжиж байгаа орон хэмээх ангилалд багтдаг, хүн амын сэтгэлгээ, соёлын хэтэрхий нээлтэй “гэнэн” байгаа зэрэг манай онцлогийг харгалзвал иймэрхүү маягийн бодлоготой байх нь зүйтэй юм. Соёлын хөгжлийг зөвхөн “үндэсний” хэмээх тодорхойлолт дээр “аргамжиж”

хаалттай болгох нь зөвхөн соёлын салбарт ч бус, нийт улс орны эрх ашигт сөрөг нөлөөтэй юм. Нөгөө талаар хэтэрхий задгай тавих тохиолдолд ардын урлаг, сонгодог урлаг гэх мэт төрийн ивээлд байдаг төрлүүд “элитийн соёл” маягтай болж, олон түмний дотор “массын соёл” давамгайлж болох талтай юм.

Бусад улс оронд хар тамхи, үр хөндөлт, гэр бүл бололгүйгээр хамтран амьдрах, ижил хүйстэний гэх мэт янз бүрийн асуудлаар яриа хэлэлцүүлэг өрнөж, жагсаал цуглаан хүртэл болдог байхад манайхан энэ болон бусад аливаа эргэлзээ маргаантай зүйлийг байх л ёстой зүйл мэтээр ойлгож урсгалаараа хүлээн авдагийг соёлын бодлогод ямар нэг хэмжээгээр харгалзах ёстой асуудал гэж үзэж байна. Ингэж хэлснээрээ энэ бүх зүйлийг сөрөг гэж үнэлж байгаа хэрэг биш. Энд эерэг сөрөгийн тухай яриагүй байна. Гагцхүү аливаа соёлын аливаа зүйлийг нийгэмийн ч, төрийн ч төвшинд дүн шинжилгээгүй хандаж байгаа нь манай орны соёлын салбар, хүн амын оюун санааны төрх төлөвт тустай биш гэсэн санааг хэлж байгаа хэрэг болно. Одоо нэгэнт “массын” маягийн соёл буй болж байгааг анхаарахгүй байж болохгүй юм. Америкаас гаралтай энэхүү соёлд соёлын эртний уламжлалтай Европын орнууд хэрхэн хандаж байгааг ч бас судлаж үзвэл тустай байж болох юм.

Соёлын тухай хуульд байгаа “соёлын дархлаа” хэмээх ойлголтыг сайтар судлаж юу гэсэн үг болохыг тодорхойлмоор санагдаж байгаа юм. Х.Дондог “монгол дархлаа” “ны тухай авч үзсэн нь соёлын дархлаатай хамаатай асуудал юм. Тэрбээр монгол дархлаа гэдэг бол янз бүрийн нөхцөлд “удам-соёлоо авч үлдэх чадвар” хэмээн тодорхойлжээ[4]. Б.Мөнхбадрал, Ж.Долгорсүрэн нар “Тухайн улс, үндэстэн, угсаатны соёлын өвөрмөц байдал, бусдаас ялгаран онцгойрох хэв маягуудад гадны нөлөө орж өөрчлөгдөх байдал, хүч түрэмгийлэн тулгаж устгах оролдлого гаргах тохиолдолд хариу үйлдэл үзүүлэх чадварыг “соёлын дархлаа хэмээн ойлгож болно” гэжээ[5]. Соёлын бодлогын хэрэгцээ талаас авч үзвэл соёлын дархлааны талаарх онолын тодорхойлолтоос гадна тодорхой парктик зорилтоор илэрхийлэгдэх ажлын тодорхойлолт хэрэгтэй юм. Учир нь соёлын үйл ажиллагааны үр дүнгийн нэгдмэл илэрхийллийн нэг нь энэхүү соёлын дархлаа юм. Ийм байр сууринаас хандвал соёлын дархлааны нэг чухал үзүүлэлт бол үндэсний хэлээрээ зөв ярьж, бичих чадвар байх жишээтэй юм.

Соёлын дархлаа нь үнэт зүйлс хэмээх ойлголттой нягт холбоотой. Үнэт зүйлс нийтийн хүртээл болж, хүн ам бүгдээрээ бус гэхэд дийлэнхи хэсэг нь тэдгээрийг итгэл үнэмшил болгож хайрладаг, дээдэлдэг, хамгаалдаг болсон тохиолдолд улс орны аюулгүй байдал, эв нэгдэл бэхжиж, соёлын нийгэм-эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө бодитой байх болно. Эдүгээ соёлын дархлаа бол зэвсэгт хүчний нэгэн адил үндэсний аюулгүй байдлыг хамгаалах хүчин зүйл болж хувирсан байна. Соёлын байгууллага, ажилтан, уран бүтээлч бүр үйл ажиллагаа, бүтээлийнхээ агуулга, чанар чансаа, ёс зүйн талыг эл хэмжүүрээр хэмжиж байвал сайн сан. Үндэсний шинжтэй юм болгоныг хааж боож байсан өмнөх үед үндэснийхээ соёлыг хамгаалж ирсэн

ахмад үеийн соёлын ажилтнууд, хаалт саад арилсаны дараа уран бүтээлээ ид туурвиж байгаа дунд үеийнхэн энэ асуудлыг сайн ойлгож, мэдэрч байна. Гагцхүү одоо түрэн гарч ирж байгаа шинэ үеийнхэн ийм итгэл үнэмшилтэй болбол соёлын дархлаа баталгаатай болно.

Үнэт зүйлс бол нэг удаа тодорхойлоод хөдлөшгүй баримталж байдаг зүйл биш. Тэдгээрийн дотор эх орон, эх хэл, төрсөн нутаг ус гэх мэт хөдлөж өөрчлөгддөггүй зүйл байх нь ойлгомжтой. Гэвч нөгөө талаар зарим зүйл бүдгэрч, алга болж, зарим зүйл шинээр буй болж байх ёстой. Тийм болохоор баримт бичигт тодорхойлогдсон соёлын бодлогын зорилго, зорилтуудыг хэрэгжүүлж соёлын дархлааг буй болгохын тулд орчин үеийн монгол хүний үнэт зүйлс юу байх ёстой вэ гэдгийг тодорхойлох нь соёлын үйл ажиллагааны агуулга юу байх, юунд мөнгө зарах ёстой вэ гэдгийг тогтооход ач холбогдолтой юм. Түүнчлэн уламжлалт үнэт зүйлсийг ч агуулгын хувьд тодорхой болгох баяжуулах шаардлага бий. Жишээлбэл, эх оронч байна гэж юу гэсэн үг вэ? Эх оронч байна гэдэг бол хэрэгцээ гарсан үед буу бариад босохоор хязгаарлагдахгүй. Тэр тусмаа гадаадынханыг харааж, зүхэх, гадуурхах явдал биш юм. Эх оронч байна гэдэг бол юуны өмнө монгол хүн монгол хүнээ хайрлана гэсэн үг, Монгол улсын нэр төрийг цэвэр ариун авч явна гэсэн үг билээ. Түүнээс гадна орчин үеийн нөхцөлд албан татварыг үнэнч шударгаар төлөх, нийтийн өмчийн зүйлсийг хайр гамтай хэрэглэх, байгаль орчноо хайрлах, эрчим хүчийг хэмнэлттэй зарцуулахаас эхлэн хог хаяхгүй байх зэрэг жижиг сажиг зүйлээр ч эх оронч сэтгэлгээ илэрнэ. Даничууд маш өндөр татавар төлдөг хэрнээ түүнийгээ эх орныхоо сайн сайханд хөрөнгө оруулж байгаа хэрэг хэмээн ойлгодог, ярьдаг байна[6].

Орчин үед байгаль орчноо хайрлан хамгаалах, хувь хүний өөрийнхөө болон нийгмийн төлөө хүлээх хариуцлага гэх мэт зүйлийн ач холбогдол нэмэгдэж байна. Үүний зэрэгцээ орчин үеийн хүн төрөлхтний нийтлэг үнэлэмжийг соёлын боловсролд харгалзан үзэх нь Монгол улс хүн төрөлхтөний их гэр бүлийн нэгэн нэр төртэй гишүүн байх боломжийг хангана. Раби Кен Спиро гол төлөв өрнөдийн оюутан залуучууд оролцсон 1500 хүнээс манай дэлхийг төгс сайхан болгохын тулд юу хийх ёстой вэ гэсэн асуулгаар судалгаа авсан байна. Тэрбээр оролцогчдын хариултыг нэгтгэсэний үндсэн дээр дараах зургаан асуудлыг оролцогчдын дийлэнх чухал гэж үзсэн байна хэмээн дүгнэжээ[7].

1. Хүний амь нас, амьдралыг хүндэтгэх. Төгс дэлхий ертөнцөд бүх хүн хэдэн суурь эрхтэй байхын дотор чухал нь амьд явах эрх юм. Хүмүүс амь насаа алдах байнгын айдасгүй, тодорхой хэмжээгээр үнэ хүндтэй байх.
2. Энх тайван ба зохицол. Хүмүүс, ард түмнүүд орон нутгийн ч, глобал төвшинд ч энх тайван, зохиолын нөхцөлд аж төрж, харилцан хүндэтгэлтэй байх.
3. Шударга ёс, тэгш байдал. Бүх хүн арьс өнгө, хүйс, нийгмийн байдлаас үл хамааран хуулийн өмнө тэгш байх.

4. Боловсрол. Хүн бүр суурь боловсрол эзэмшиж, нийгэмд аж төрөхөд зайлшгүй шаардлагатай чадвэр эзэмшсэн байх.
5. Гэр бүл. Бат бэх, тогтвортой гэр бүл нь нийгмийн ёс суртахуугу суурь, хүүхдийг нийгэмшүүлэх болон боловсролтой болгох чухал институтын хувьд оршин байх.
6. Нийгмийн хариуцлага. Хувь хүний, орон нутгийн, улс орныхоо болон глобал төвшинд хүмүүс эх дэлхийнхээ төлөө хариуцлага хүлээх. Энэ нь өвчин, ядуурал, ган зуд, гэмт хэрэг, хорт зуршилтай холбоотой асуудлууд болон байгаль орчин, амьтдыг хамгаалах зэрэг нийтлэг тулгамдсан бэрхшээлүүдийг шийдвэрлэх зохион байгуулалттай нийгмийн сүлжээтэй байхыг шаардана.

Эдгээр үнэт зүйлс монголчуудын үнэлэмжид ч дээгүүр байр суурь эзлэнэ. Үнэт зүйлсийг төрийн төв байгууллагууд, улстөрийн аль нэг хүчин, төрийн бус байгууллага, эсвэл эрдэмтэн судлаачдын аль нь ч тогтоохгүй. Ингэвэл иргэдэд эрх барьж буй хүчний юмуу, аль нэг бүлэглэлийн, эсвэл элитийн соёлыг тулган хүлээлгэсэн хэрэг болно. Үнэт зүйлс нь хувь хүний хувьд түүний суурь хэрэгцээтэй, улс орны хувьд өөртөө эзэрхэн хөгжиж цэцэглэх хэрэгцээтэй нягт холбоотой. Хувь хүний болон нийгмийн төвшний үнэт зүйлс нь хоорондоо нягт холбоотой бөгөөд нэг нь нөгөөгөө нахцөлдүүлж байдаг. Гэвч хүний суурь хэрэгцээ хангагдахгүй байх нөхцөлд улс нийгмийн төвшний үнэт зүйлсийг ухамсарлахгүй байх, улс оронд дарангуйлал, захиргаалтын дэглэм тогтох, элитийн төвшинд хагарал, заврхрал гарах үед хувь хүний төвшний үнэт зүйлсийг төдийлэн анхаарахаа болих гэх мэтээр үнэт зүйлсийн хямрал гардаг байна.

Нэгэнт үнэт зүйлс хэрэгцээтэй уялдаатай байдаг болон дээр дурдсан хоёр төвшний үнэт зүйлс өөр хоорондоо уялдаатай байдаг учраас ард түмнийг бүхэлд нь авч үзвэл түүний ядахдаа дийлэнхи хэсэг нь тухайн улс орны хувьд чухал үнэт зүйлсийн талаар нийтлэг ойлголттой, дор хаяж тийм мэдрэмжтэй байдаг. Тийм учраас түүхэн тодорхой нөхцөлд эдгээр үнэт зүйлсэд чухам юу багтаж, дотроо ямар эрэмбэтэй байгааг судлах нь чухал юм. Тэгэхдээ энэ бол үнэт зүйлсийн төлөвшил, өөрчлөлт, хувиралд төр засгийн болон бусад байгууллагууд, соёлын зүтгэлтнүүд ямар ч нөлөөгүй гэсэн үг биш. Ингэж үзэх юм бол соёлын боловсролын талаар ярих ч хэрэггүй болно. Хэрэглээг хэт шүтсэн, хүнд угаасаа байдаг, араатанлаг, болхи бүдүүлэг зан авир, мэдрэмжийг хязгаарлах, хүмүүнлэг ёсыг дээдлэх үзэл, үйл ажиллагааны дадал чадварыг төлөвшүүлэхэд чиглүүлэн соёлын боловсролыг хөгжүүлэхэд соёлын бодлого явуулах нь зүйн хэрэг. Нөгөө талаар дэлхий ертөнцийн байдал, ирээдүй цагийн төлөвийг харгалзан үнэт зүйлсийн өөрчлөлтөд, өөрөөр хэлбэл, хүн амын соёлд нөлөөлөх хэрэгцээ зайлшгүй бий.

Монгол Улсын хувьд соёлын бодлоготоо зайлшгүй харгалзах ёстой зарим асуудал байна. Юуны өмнө энэ нь хот хөдөөгийн, ахмад болон залуу үеийн соёлын ялгааны тухай асуудал хамаарна. Хот хөдөөгийн хувьд ялгаа

нь соёлын өндөр намын тухайд бус, харин хоёр өөр хэв маягийн соёлтой болж зааграх магадлал ажиглагдаж байна. Хот хэтэрхий өрнөджиж, хөдөө уламжлалт соёлоо хадгалах маягтай ажиглагдаж байна.

Дараагийн асуудал нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд соёлын нөлөөг дээшлүүлэхтэй холбоотой юм. Нийгэм, эдийн засгийн хөгжилд соёл чухал нөлөөтэй байдаг тухай асуудал одоо нэгэнт мэтгэлцээний сэдэв байхаа больжээ. Хуулиар засаж болдоггүй, соёлын боловсролоор засаж болдог зүйлс ч бий. Тийм учраас монголчуудын стандарт маягийн соёл болон шинээр буй болж буй соёлд нийгэм, эдийн засгийн хөгжилд түлхэц болж байгаа болон эсрэгээрээ сөрөг нөлөө үзүүлж буй зүйлсийн талаар судалгаа хийх, шинжлэж дүгнэх, улмаар соёлын боловсролд харгалзах хэрэгтэй байна. Авлига, сонгуулийн будлиан, засаг төрийн тогтворгүй байдал, бодлогын тасалдал зэрэг улс төрийн хүрээний “согог”-оос эхлэн хувь хүний ажилдаа хадаж буй байдал хүртэлх олон зүйлд соёлын тумагшил нөлөөтэй байгаа юм. Соёлын болон нийгэм эдийн засгийн хүрээний харилцаа зөвхөн нэг талтай бишээ.

Судлаачид соёлын болоннийгэм, эдийн засгийн хүрээ харилцан уялдаатай болохыг тэмдэглэсэн байдаг. “Хүн хүссэн ажил хөдөлмөрөө сэтгэл ханамжтай эрхлэх, чанартай боловсролыг эзэмших, эрүүл аюулгүй орчинд амьдрах, үр хүүхдээ өсгөх соёлын эрх чөлөөний нөхцлийг ард иргэддээ амсуулах төдийгүй эдлүүлэх нь төрийн соёлын бодлого мөн. Өөрөөр хэлбэл соёлын сонголт хийх бүрэн чадамжтай боломжтой дундаж давхрааг тэлэх өргөтгөх нь Монгол Улсын төрийн урт хугацааны бодлогын үндсэн чиглэлүүдийн нэг билээ”[8]. Тийм болохоор соёлын бодлого нь нийгэм, эдийн засгийн бодлого зэрэг төрийн бодлогын бусад чиглэлүүдтэй нягт уялдаатай байх ёстой байна.

Өөр нэг асуудал байгаа нь даяаршилтай холбоотой. Хэдийгээр дайн дажин гарч дэлхийн байдал төвөгтэй байгаа ч гэсэн даяаршлын үйл явц саарна уу гэхээс биш, тасалдаж, алга болохгүй бололтой. Үүнд орчин үеийн шинжлэх ухаан, технологийн хувьсгал нөлөөлж байна. Ялангуяа оюун санааны хүрээнд энэ үйл явц улам бүр хүчтэй болох төлөвтэй байна. Тийм болохоор соёлын дархлааны талаар ярихын зэрэгцээ асар хурдацтай өөрчлөлтийн эрин үед хүн амын соёлын адилсалыг хэрхэн хадгалах вэ гэдэг асуудал чухал болж байна. Энэ нь хүн амын дэд бүлгүүд, ястнуудын соёлын төрх төлвийг судлах, тэдгээрийн холбоо, харилцаа, солилцоо, баяжилтийг хүчтэй болгох, тэдгээрт монголын ард түмний нийтлэг үнэт зүйлсийг шингээх, хүн амын хэсэг бүлэг бүрт соёлын үнэт зүйлсийн хүртээмжийг жигд, хангалттай хүргэх зэрэг олон асуудлыг багтааж байгаа юм.

Соёлын харилцааг босоо чиглэлд төдийгүй хэвтээ чиглэлд хүчтэй болгох үүнд тустай байж болно. Тухайлбал, аймаг хоорондын соёлын солилцоо, орон нутгийн хүн амын төвийн урлаг соёлын тэргүүлэх байгууллагуудын үйлчилгээг байнга хүртэх боломжийг нэмэгдүүлэх, соёлурлагийн нэртэй зүтгэлтнүүдийн нийгэмд үзүүлэх нөлөөг дээшлүүлэх гэх мэт үйл ажиллагааг зорилготойгоор зохион байгуулах нь тустай байж

болох юм. Урлагийн чанартай бүтээлүүд ч бас чухал нөлөөтэй юм. Жишээлбэл, “халуун элгэн нутаг” хэмээх дуу, “Миний нутаг”, “есөн эрдэнийн орон” зэрэг шүлгүүд нь хүн амын соёлын адилсал, эх оронч үзэлд ихээхэн нөлөөтэй байгаа нь ажиглагддаг.

Соёлын бодлогын баримт бичгүүдэд иргэдийг “соён гэгээрүүлэх” гэсэн зорилт тусгагдаж байгаа хэдий ч манай орны өнөөгийн нөхцөлд нэлээд тодорхой дэвшүүлж, хэрэгжүүлэх соёлын зорилтын нэг нь иргэдэд шинжлэх ухааны мэдлэг олгох явдал юм. Энэ нь хүнд соёлын сонголтыг чөлөөтэй хийхдээ ухамсартай хандаж, зөв сонголт хийх бололцоог олгоно. Шинжлэх ухааны мэдлэгтэй хүн хэдийгээр шашшин шүтдэг байж болох ч мухар сүсэгт автахгүй гэдэг нь лавтай юм. Дэлхий дахинд өнөөдөр “цахим тайлагдалт”, “шинжлэх ухааны тайлагдалт” хэмээх ойлголт буй болж үүний дагуу улс орнууд төсөл, хөтөлбөр гаргаж, зарим оронд хүн амын насны бүлэг бүрт зориулан агуулгыг нь баяжуулж нарийсгасан хөтөлбөр хүртэл гаргажээ. Гэтэл манай оронд мухао сүсэг нэлээд газар авч байгаа ба энэ зарим тохиолдолд “үндэсний соёл”-ыг сэргээх уриан дор явж байна.

Бодлого амжилттай хэрэгжсэн тохиолдолд л ач тусаа өгнө гэдэг нь ойлгомжтой юм. Асуудлыг энэ талаас нь авч үзвэл хамгийн том бэрхшээл бол иргэдэд соёлын боловсрол олгох, соён гэгээрүүлэхэд нөлөө бүхий байгууллага, хүмүүсийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, соёлын бодлогын зорилгуудыг хэрэгжүүлэхэд төстэй ойлголттой, үйл ажиллагаагаа уг зорилгуудтай нийцүүлэн явуулдаг болгох нь чухал юм. Одоогийн байдлаар энд л хамаг бэрхшээл байх шиг ажиглагдаж байна. Ардчиллын нөхцөлд ч ийм уялдуулан зохицуулах үйл ажиллагаа явуулж болдогийг Европын зарим орны жишээ харуулж байгаа юм.

Одоогийн байдлаар бодлогын зарим зорилтын хэрэгжилт туйлын хангалтгүй байна. Үүнийг жишээ нь монгол хэлний хэрэглээний өнөөгийн байдал бэлхнээ харуулна. Гадаад хэлний үг оруулан (шууд гадаад үг хэрэглэх юмуу, эсвэл түүнийг махчилан орчуулах маягаар) ярихаас гадна монгол хэлний хэм хэмжээг зөрчих зэрэг олон гажиг ажиглагдаж байна. Хэл бол соёлыг тээгч, түүний махбодь, оюун ухаан нь юм. Хэл эвдэрвэл соёлыг хамгаалж байгаа болон хөгжүүлж байгаа тухай ярихын ч хэрэггүй болно. Үүнийг манай ухаант мэргэд бүр эртнээс мэдэж хэлээ хамгаалах талаар санаа тавьж, арга хэмжээ авч байжээ. Тухайлбал, 1924 онд Судар бичгийн хүрээлэнгийн нэр томъёоны комиссоос монгол хэлний үг үсгийг жигдлэх, гадаад үгийг орчуулах талаар шийдвэр гаргаж байжээ. Тиймээс соёлын бодлогын зорилгод үндэсний хэлээ хамгаалах, хэлний тусламжтайгаар үндэсний адилсалыг улам бэхжүүлэх асуудал том байр эзлэх нь зүй юм.

Ашигласан материал

1. Ploeg, Frederick van der. The Making of Cultural Policy: A European Perspective. CESFIO Working Paper No.1524. https://www.ifo.de/DocDL/cesifo1_wp1524.pdf
2. Girard A., Gentil G. (1983). Cultural development: experiences and policies, 2nd ed. Paris, UNESCO,

3. Хренов А. Е. (2013). Модели культурной политики: смена парадигм. Труды Санкт-Петербургского государственного института культуры. <https://cyberleninka.ru/article/n/modeli-kulturnoy-politiki-smena-paradigm/viewer>
4. Востряков Л. Культурная политика: Основные концепции и модели. <http://culture29.ru › upload › medialibrary>
5. Монгол Улсын Соёлын тухай хууль.
6. Дондог Х. (2019). Монгол дархлаа нь бидний үнэт зүйл болох нь. *Монголын соёл, урлаг судлал*. Tomus XXXI, Fasciculus 1-20. pp. 100-110
7. Мөнхбадрал Б, Долгорсүрэн Ж. (2016). Соёлын дархлаа хэмээх ойлголтын тухайд. *Монголын соёл, урлаг судлал*. Tomus XX, Fasciculus 49, pp. 174-183
8. Wiking, Meik. (2017). The little book of HYGGE: Danish secrets of happy living. William Morrow. An imprint of harper Collins Publishers. p. 7
9. <https://illuminatetheworld.com/world-perfect-where-did-the-values-and-principles-of-the-modern-world-come-from/>
10. Пүрэвсүрэн Б. (2021). Хэл, соёлын онтологи. Уб., 158 дахь тал

Бусад эх сурвалж

1. Төрөөс соёлын талаар баримтлах бодлого
2. Батдорж Ч., Н. Хишигт, С. Чулуун. (2021). Монгол Улсын шинжлэх ухааны түүх. Боть 1. Уб.,
3. Dallaire Geraldine., Francois Colbert. (2012). Sustainable Development and Cultural Policy: Do they Make A Happy Marriage? Encarc.org/media/2701-journal_vol-2-issue-1-2012712.pdf
4. Martel Par Frederic. (2020). Cultural policies: Mapping a field in reinvention. https://www.zhdk.ch/file/live/e1/e123ea364fca50c558cb3465c7abaca4e1e78b22/2020_03_cultural-policies-mapping-a-field-in-reinvention-frederic-martel_article.pdf
5. Как поддерживают культуру в разных странах мира. Афиша Dailly <https://daily.afisha.ru/archive/vozduh/art/kak-podderzhivayut-kulturu-v-raznyh-stranah-mira/>